



## БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгоны Сум дундын Ойн ангийн  
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** БУА-2025/001/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: <a href="http://www.open.audit.mn">www.open.audit.mn</a></p> <p>Булган аймаг 2025 он</p>	<p>Дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 7034-2580 Цахим хаяг: <a href="mailto:enkhtsoodolj@audit.gov.mn">enkhtsoodolj@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Цахим хаяг: <a href="mailto:enkhtsoodolj@audit.gov.mn">enkhtsoodolj@audit.gov.mn</a></p> <p>Аудитор: Г.Цэрэнлхам Цахим хаяг: <a href="mailto:Tserenlkhamg@audit.gov.mn">Tserenlkhamg@audit.gov.mn</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **АГУУЛГА**

---

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	15
4.1 Ерөнхий зүйл .....	15
4.2 Материаллаг байдал .....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
4.5.1 Завсрын аудитын талаар .....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	18
5.1 Төлбөрийн акт .....	18
Төлбөрийн акт тогтоогдоогүй болно .....	18
5.2 Албан шаардлага .....	18
5.3 Зөвлөмж .....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	20

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББ	Нягтлан бодох бүртгэл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт /Баталгаажсан хувийг оруулах/



### БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,  
63082, Утас/Факс: 7034-2580  
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.08.13

№

339

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

БУЛГАН АЙМГИЙН ХАНГАЛ СУМЫН  
ХЯЛГАНАТ ТОСГОНЫ СУМ  
ДУНДЫН ОЙН АНГИЙН ДАРГА  
М.НЯМЖАРГАЛ ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хангал сумын Хялганат тосгоны Сум дундын ойн ангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хангал сумын Хялганат тосгоны Сум дундын ойн ангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

#### Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

#### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 24 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс ҮСХ-ны даргаар 87.5 хувьтай үнэлүүлэн "маш сайн" үнэлгээ авсан байна. Шалгагдагч байгууллагын санхүүгийн

632502666

тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захиаргчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 Ж.ЭНХЦООДОЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

(мянган төгрөг)

	Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	3,126.9	3,126.9
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	83,945.7	124,140.1
	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>87,072.6</b>	<b>127,267.0</b>
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	87,072.6	127,267.0
	<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>87,072.6</b>	<b>127,267.0</b>
<b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>			
	Үйл ажиллагааны орлогын дүн	151,969.0	198,027.1
	Үйл ажиллагааны зардлын дүн	163,446.0	195,012.6
	<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>(11,477.0)</b>	<b>3,014.5</b>
	Үйл ажиллагааны бус үр дүн	(2,100.3)	(0.0)
	<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>(13,577.3)</b>	<b>3,014.5</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	100,649.9	105,397.4
	Тайлант оны үр дүн	(13,577.3)	3,014.5
	<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>87,072.6</b>	<b>108,411.8</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	149,306.3	197,089.1
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	144,306.3	182,089.1
	<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	<b>5,000.0</b>	<b>15,000.0</b>
	<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	<b>(5,000.0)</b>	<b>(15,000.0)</b>
	<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>	-	-
	<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>			
	<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	-	168,699.4
	Урсгал зардал	-	153,699.4
	Хөрөнгийн зардал	-	15,000.0
	<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	-	168,699.4
	Улсын төсвөөс санхүүжих	-	-
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	65,952.5

## **Гурав. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 1,978.6 мянган төгрөгийн 1 алдаа<sup>1</sup> илэрснээс, зөвлөмж өгч ажиллалаа. Үүнд:

### **1. Зардалтай холбоотой асуудал**

Илрүүлэлт 1: Нөхөрлөл аж ахуй нэгжүүдтэй хийлгэсэн талбай тусгаарлалтын гэрээний дүнгээр и-нэхэмжлэл үүсгэж, тооцоо нийлээгүй нь Сангийн сайдын "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуй нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны маягтыг нөхөх заавар" 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан журам, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Өөрийн орлогод гэрээг үндэслэн нэхэмжлэх үүсгэж, тухай бүр тооцоо нийлж хэвших

Аудитаар залруулагдаагүй 1 зөрчилд, зөвлөмж өгч ажиллалаа. Нийт залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 473.1 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

#### **5.1 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

#### **5.2 Албан шаардлага**

Албан шаардлага өгөгдөөгүй.

#### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Орлоготой холбоотой асуудал**

Илрүүлэлт 1: Нэмэлтийн санхүүжилийн данснаас шатахуун, томилолт, бичиг хэргийн материалыг 210801 зардлын эдийн засгийн ангиллаас зориулалт бусаар зарцуулсан нь Сангийн сайдын "Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай" 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан журам, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Нэмэлт санхүүжилтийн данснаас зарцуулах эрх нээлгэхдээ зардлын эдийн ангиллын дагуу эрх нээлгэж, зарцуулж хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

## Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	(мянган төгрөгөөр)											
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нөхөрлөл аж ахуй нэгжүүдтэй хийлгэсэн талбай тусгаарлалтын гэрээний дүнгээр и-нэхэмжлэл үүсгэж, тооцоо нийлээгүй.	1	1,978.6			1	1,978.6					1	1,978.6
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>1,978.6</b>			<b>1</b>	<b>1,978.6</b>					<b>1</b>	<b>1,978.6</b>

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	(мянган төгрөгөөр)											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Албан тушаалтны тоо			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нэмэлтийн санхүүжиллийн данснаас цалин олгож, материалыг 210801, 210901 зардлын эдийн засгийн ангиллаас зориулалт бусаар зарцуулсан.	1	-					1	-				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>					<b>1</b>	<b>-</b>				

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						Зөвлөмж	
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Төо			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<p>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</p> <p>Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл – Хөтөлбөр, зориулалт, Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт-эдийн засгийн ангиллийн 7 дугаар сарыг хугацаа хоцроосон, хавсралт файл оруулсан боловч, тухайн мэдээллийг нотлох баримтыг хавсралт файл хэсэгт оруулж мэдээлээгүй байна.</p>	-	-	-	-	-	-	-	-	1	-
<b>Дүн</b>	-	-	-	-	-	-	-	-	1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Зөрчил илрээгүй.										
<b>Дүн</b>										
<b>Нийт дүн</b>										